



ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН МАТЕРИАЛ

2025.07.07

АГУУЛГА

- 03 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ын зар
- 04 ХЭЭБХ-ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн тогтоол
- 06 ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:
Шийдвэрлэх асуудал:
- 07 1. ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: Монгол хэл дээрх эхийг англи хэл дээрх эхэд нийцүүлэх.
- 11 2. ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай: Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоох.
- 17 Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолын төсөл
- 21 Тооллогын комиссын бүрэлдэхүүн
- 22 Саналын хуудасны загвар

ХАСБАНК ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ЗАРЛАЛ

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгийг үндэслэн ХасБанк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-28 дугаар тогтоолын дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”) -ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буйг үүгээр зарлаж байна.

Компанийн нэр, байршил: ХасБанк ХК, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Ерөнхий Сайд Амарын гудамж, ХасБанкны Төв Байр, ШХ 20А, 72.

Хувьцаа эзэмшигчдэд саналын хуудас хүргүүлэх өдөр: 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Брокер, дилерийн компаниудад хүргүүлж, ХасБанкны вебсайт, ХасМийтинг (ХасMeeting) аппликейшнд байрлуулна.

Эчнээ санал цахимаар хүлээн авах хугацаа: 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд хүлээн авна.

Бүртгэлийн өдөр: ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр байна.

ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудал:

1. ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: Монгол хэл дээрх эхийг англи хэл дээрх эхэд нийцүүлэх.
2. ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай: Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоох.

Хувьцаа эзэмшигч та хурлын материалтай танилцах бол 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн банкны цахим хуудсанд (www.xacbank.mn) эсвэл хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшн-д хандах боломжтой. Та эчнээ саналаа заасан хугацаанд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгнө үү.

Холбоо барих:

Утас: +(976)-8508-1888

Цахим шуудангийн хаяг: investor-relations@xacbank.mn

Ажиллах цагийн хуваарь: ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд.

2025 оны 07 дугаар сарын 02-ны өдөр

ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХЭЭБХ-ЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ХЭЛБЭРЭЭР, ЦАХИМААР ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ТОГТООЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 06 сарын 27 өдөр

№ R-2025-28

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хороо ("СЗХ")-ны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ НЬ:

1. ТУЗ 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолоор Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулахаар шийдвэрлэснийг; мөн
2. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг эцэслэн батлах зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалт хэлбэрээр, цахимаар зохион байгуулах нь зүйтэй гэж ТУЗ үзсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ НЬ:

1. Банкны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал ("ХЭЭБХ")-ыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж хуралдуулсугай.
2. ХЭЭБХ Зохион байгуулах комиссын даргаар Банкны Ерөнхий аудитор Э.Ундармааг томилсугай. Тус комиссын гишүүдийг холбогдох дотоод журмын дагуу томилохыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд үүрэг болгосугай.
3. ХЭЭБХ-ын мэдэгдлийг 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор СЗХ болон Монголын Хөрөнгийн Бирж ("МХБ")-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.
4. ХЭЭБХ зохион байгуулах тухай зар мэдээг МХБ-ийн цахим хуудас, өдөр тутмын сонин, Банкны албан ёсны веб сайт (www.xacbank.mn), сошиал орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2025 оны 07 дугаар сарын 02-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, зарын давталтыг тийнхүү нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа анх зарласан хэлбэрээр дахин нэг удаа нийтэд мэдээлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
5. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 07 дугаар сарын 21-ний өдөр байхаар тогтоосугай.

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

6. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, саналын хуудас болон бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 07 дугаар сарын 07-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
7. ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудлыг 1 дүгээр хавсралтаар, ХЭЭБХ-аар шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар, Тооллогын комиссын бүрэлдэхүүнийг 3 дугаар хавсралтаар, саналын хуудсыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчид шийдвэрлэх асуудалтай холбоотой баримт бичигтэй ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулагдсан ХасМийтинг аппликейшнээр дамжуулан танилцах боломжийг хангаж ажиллахыг Зохион байгуулах комисст даалгасугай.
9. Эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар зохион байгуулж буй ХЭЭБХ-аас гарсан шийдвэр, бусад холбогдох баримт бичгүүдийг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд МХБ, СЗХ-д хүргүүлэхийг ТУЗ-ийн Ажлын албанд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ



Хурлаар шийдвэрлэх асуудал:

- ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай: Монгол хэл дээрх эхийг англи хэл дээрх эхэд нийцүүлэх;
- ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай: Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоох.

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Банкны дүрмийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална” гэж заасан. Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”) уг заалтыг дахин хянаж үзэхийг зөвлөмж болгосны дагуу Банкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТҮЗ”) нь тус заалтад өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр болсон. Ингэхдээ, Дүрмийн монгол болон англи хэл дээрх эхийн хооронд зөрүү байгаа эсэхийг хөндлөнгийн хуулийн зөвлөхөөр хянуулах ба эхүүд материаллаг зөрүүгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд ийнхүү санал болгохоор шийдвэрлэсэн юм.

Гүйцэтгэх удирдлага дээрх шийдвэрийн дагуу хөндлөнгийн хараат бус хуулийн зөвлөх (монгол эхийг англи эхээс орчуулж бэлтгэсэн хөндлөнгийн хуулийн фирмээс тусдаа хуулийн фирм)-өөр зөрүүг нягтлуулсан бөгөөд тус хуулийн зөвлөх нь тодорхой нэмэлт, өөрчлөлтүүдийг Дүрмийн монгол хэл дээрх эхэд оруулахаар санал болгосон.

Ийнхүү орчуулгуудыг хянан үзсэний үндсэн дээр гүйцэтгэх удирдлагаас санал болгосны дагуу ТҮЗ 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолоор i) Банкны Дүрмийн монгол эхийг англи эхэд нийцүүлэх, мөн ii) монгол болон англи эхийн хооронд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлах нэмэлт, өөрчлөлтүүдийг Банкны Дүрэмд оруулахаар ийнхүү хувьцаа эзэмшигчдэд танилцуулж байна.

Дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд: Монгол хэл дээрх эхийг англи хэл дээрх эхэд нийцүүлэх

(Монгол хэл дээрх эхэд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд)

д/д	Заалт	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт	Тайлбар
1	1.5.25	1.5.25 "Super Majority" shall mean no less than 66.67 (sixty six and sixty seven hundredths) percent of the total number of votes, voting rights, shares, or shareholders where applicable as the context may require;	1.5.25 "Дийлэнх олонх" гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67 (жаран зургаа зууны жаран долоо)-оос дээш хувийг;	1.5.25 "Дийлэнх олонх" гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67 (жаран зургаа зууны жаран долоо)-оос доошгүй дээш хувийг;	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулгыг оновчтой болгон өөрчлөхөөр ирүүлсэн санал. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн. Англи эхэд зааснаар 66.67%-ийн саналтай тогтоол нь хүчин төгөлдөр болох боловч одоогийн монгол эхийн дагуу хүчин төгөлдөр бусад тооцогдохоор байна.
2	1.5.26	1.5.26 "Ultra Majority" shall mean no less than 75 (seventy five) percent of the total number of votes, voting rights, shares, or shareholders where applicable as the context may require;	1.5.26 "Үнэмлэхүй олонх" гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75 (далан тав)-аас дээш хувийг;	1.5.26 "Үнэмлэхүй олонх" гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75 (далан тав)-аас доошгүй дээш хувийг;	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулгыг оновчтой болгон өөрчлөхөөр ирүүлсэн санал. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн. Дээр дурдсантай адил 75%-ийн саналтай тогтоол монгол эхийн дагуу хүчингүй болох эрсдэлтэй.
3	5.4.8.2	5.4.8.(2) making false statements to investigators in order to materially impede a Bank investigation into allegations of a Prohibited Practice;	5.4.8.2 Хориглосон үйл ажиллагааны хүрээнд Банкинд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах;	5.4.8.2 Хориглосон үйл ажиллагаа байж болзошгүй тохиолдлын ажиллагааны хүрээнд Банкинд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд ноцтой саад учруулах зорилгоор хянан шалгагч нарт худал жуурамч мэдээлэл өгөх;	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулгыг оновчтой болгон өөрчлөн найруулах, мөн орчуулагдаагүй орхигдсон "allegations" (байж болзошгүй тохиолдол) болон "materially" (ноцтой) гэсэн үгсийн орчуулгыг нэмэхээр санал ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн.
4	7.7	7.7 Subject to clause 7.6 above, the total quantity, par value, interest rate, periods for interest payments, price and redemption price of the additional Shares and other securities convertible to Shares, and convertibility of the securities into the Shares shall be determined by the BoD for the final approval and resolution from the shareholders' meeting.	7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон бусад үнэт цаас, хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.	7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон Хувьцаанд хөрвөх бусад үнэт цаасны, хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнэ болон үнэт цаасны Хувьцаанд хөрвөх нөхцөлийг үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулгыг оновчтой болгон өөрчлөн найруулах, мөн орчуулагдаагүй орхигдсон "and convertibility of the securities into the Shares" (үнэт цаасны Хувьцаанд хөрвөх нөхцөл) гэсэн хэсгийн орчуулгыг нэмэхээр санал ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн.
5	8.5	8.5 Except as otherwise provided in the Applicable Law or this Charter, decisions of the shareholders' meeting shall be made by a Simple Majority vote of shareholders present in person or by proxy at such meeting and eligible to vote on the matter. Each shareholder present in person or by proxy at the meeting shall have one vote for each Share of which he/she is the holder.	8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон хувьцаа эзэмшигчдийн Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.	8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, өрөлцөөн тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулагдаагүй орхигдсон "and eligible to vote on the matter" (тухайн асуудлаар санал өгөх эрхтэй) гэсэн хэсгийн орчуулгыг нэмэхээр санал ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн. Энэхүү орхигдуулсан хэсэг нь хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргах санал хураалтад оролцох эрхтэй этгээдийг тодорхойлсон учир шийдвэрийн хүчин төгөлдөр байдалд шууд нөлөөлнө.

д/д	Заалт	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт	Тайлбар
6	8.6.7	8.6.(vii) making any investments including by way of deposits, loans, share capital in any concern other than in the ordinary course of business for the amount exceeding 2 (two) percent of the total equity of the Bank as per the most recent audited accounts of the Bank, in accordance with IFRS;	8.6.(vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр компанид хөрөнгө оруулах;	(vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, <u>хувь нийлүүлсэн</u> хөрөнгө <u>хуваах</u> зэргээр компанид хөрөнгө оруулах;	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс “share capital” (хувь нийлүүлсэн хөрөнгө) гэснийг “хөрөнгө хуваах” хэмээн буруу орчуулсан байгааг онцолсон. Гүйцэтгэх удирдлагын зүгээс санал болгосон орчуулгыг зөв орчуулга хэмээн үзэж байна.
7	8.6.11	8.6.(xi) the sale, conveyance, transfer, rent or other disposition of any assets with a value of more than 25 (twenty five) percent of the total assets of the Bank.	8.6.(xi) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны нийт хөрөнгийн 25 (хорин тав) хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, тээвэрлэх, шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.	(xi) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны нийт хөрөнгийн 25 (хорин тав) хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, <u>өмчлөх эрхийг шилжүүлэх</u> тээвэрлэх , шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.	Монгол эхэд “Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр” гэсэн англи эхэд байхгүй илүүц хэсгийг нэмсэн байна. Түүнчлэн “conveyance” (өмчлөх эрхийг шилжүүлэх) гэснийг “тээвэрлэх” хэмээн буруу орчуулжээ.
8	8.26.2	8.26.2 making any investments including by way of deposits, loans, share capital in any concern other than in the ordinary course of business for the amount up to 2 (two) percent of the total equity of the Bank as per the most recent audited accounts of the Bank, in accordance with IFRS;	8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-н хамгийн сүүлд аудитлагдсан дагуу Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;	8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, <u>хувь нийлүүлсэн</u> хөрөнгө <u>хуваах</u> зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс “share capital” (хувь нийлүүлсэн хөрөнгө) гэснийг “хөрөнгө хуваах” хэмээн буруу орчуулсан байгааг онцолсон. Гүйцэтгэх удирдлагын зүгээс санал болгосон орчуулгыг зөв орчуулга хэмээн үзэж байна.
9	10.2	10.2 Any implemented dissolution by a shall be Dissolution Commission which shall be appointed by the BoD or the trustee appointed by the court, in the event the dissolution is by a court decision.	10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах тохиолдолд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс томилогдсон Татан буулгах комисс хэрэгжүүлнэ.	10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс томилогдсон Татан буулгах комисс <u>эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах тохиолдолд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч</u> хэрэгжүүлнэ.	Одоогийн монгол эхэд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч нь Татан буулгах комиссыг томилохоор заажээ. Энэ нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн этгээдийг татан буулгах тухай Монгол Улсын хууль тогтоомжид үл нийцнэ. Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс татан буулгах ажиллагааг нэг бол “ТУЗ-өөс томилсон Татан буулгах комисс эсхүл шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч хэрэгжүүлнэ” хэмээн илүү оновчтой орчуулгыг санал болгосон.

д/д	Заалт	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт	Тайлбар
10	11.2.2	11.2.2 Perform their duties in good faith, not provide unlawful or unethical advantage to themselves, their family, relatives, nor others who are in business or have personal relations with them or their family or relatives; Unless otherwise specified in law or internal rules and regulations, not disclose to others, or allow to be used by others, or use for private interest, any information about customers' accounts statements, loans, transactions and documents related to the business activities, figures, internal procedures, regulations, terms and conditions.	11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, болон ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус давуу байдал олгохгүй байх; Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.	11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба <u>банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар</u> өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, болон ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус, <u>ёс зүйд үл нийцэх байдлаар</u> давуу байдал олгохгүй байх; Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, <u>заавар нөхцөл, болзлуудыг нөхцөлүүдийг</u> хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад <u>задруулах танилцуулах</u>, ашиглуулах, <u>нууцлалыг—алдагдуулах</u>, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.	Одоогийн монгол эхэд “unlawful,” (хууль бус) гэсэн шалгуурыг оруулсан ч илэрхий тусгасан “unethical” (ёс зүйд үл нийцэх) гэсэн шалгуурыг орхигдуулсан байх бөгөөд “банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар” гэсэн илүүц хэсгийг нэмсэн байна. Ирүүлсэн саналд “хууль бус, ёс зүйд үл нийцэх байдлаар” гэсэн хэсгийг нэмж, банкны процедурын тухай илүүц хэсгийг хассан. Бусад өөрчлөлтүүд нь редакцын хянан тохиолдуулга болно.
11	12.1.1	12.1.1 insure and keep insured on terms and conditions acceptable to the shareholders, with a reputable insurer or insurers all its assets, business and liabilities which can be insured, against insurable losses, on a reinstatement basis utilizing current full replacement values, and any other insurance required by law. The policies shall be in the English language;	12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага мөн хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад эрсдэлийг салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр даатгуулах буюу өмнө байгуулсан гэрээний хугацааг сунгана. Даатгалын гэрээг англи хэл дээр байгуулна;	12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага, <u>аливаа бусад даатгалын зүйл болохуйц эрсдэлийг одоогийн үнээр нь нөхөн төлөх нөхцөлөөр мөн заавал даатгуулахаар заасан аливаа бусад эрсдэлийг</u> салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр <u>даатгуулж, уг даатгалуудыг хүчин төгөлдөр хэвээр байлгах ба үүнд хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад даатгал мөн орно. даатгуулах буюу өмнө байгуулсан гэрээний хугацааг сунгана.</u> Даатгалын гэрээг англи хэл дээр байгуулна.	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулагдаагүй орхигдсон “against insurable losses, on a reinstatement basis utilizing current full replacement values” (аливаа бусад даатгалын зүйл болохуйц эрсдэлийг одоогийн үнээр нь нөхөн төлөх нөхцөлөөр) гэсэн хэсгийн орчуулгыг нэмэхээр санал ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн.
12	13.3	13.3 This Charter shall be amended only by an Ultra Majority vote of shareholders present at the meeting in person or by proxy and eligible to vote on such matter. Each shareholder present in person or by proxy shall have one vote for each Share of which he/she is the holder.	13.3 Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.	Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, <u>тухайн асуудлаар санал өгөх эрхтэй</u> гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ	Хөндлөнгийн хуулийн зөвлөхөөс орчуулагдаагүй орхигдсон “and eligible to vote on the matter” (тухайн асуудлаар санал өгөх эрхтэй) гэсэн хэсгийн орчуулгыг нэмэхээр санал ирүүлсэн. Гүйцэтгэх удирдлага дэмжсэн.

Дүрэмд оруулах өөрчлөлт: Зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоох

(Монгол болон англи хэл дээрх эх тус бүрд оруулах өөрчлөлт)

Одоогийн англи заалт	Өөрчлөлт орсон англи заалт
13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English version shall prevail in any discrepancies in the two versions.	13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English Mongolian version shall prevail in any discrepancies in the two versions.

Одоогийн монгол заалт	Өөрчлөлт орсон монгол заалт
13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална.	13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи монгол хэл дээрх эхийг баримтална.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



2025 оны 06 сарын 27 өдөр

№ R-2025-27

Улаанбаатар хот

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК ("Банк")-ийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлаар дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо ("СЗХ") 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 9/3889 тоот албан бичгээр Банкны Дүрмийн 13.7 дахь хэсгийг дахин хянаж үзэхийг зөвлөмж болгосныг;
2. Банкны Дүрмийн монгол болон англи хэл дээрх эхийн хооронд зөрүүгүй болохыг хөндлөнгийн хуулийн зөвлөх баталгаажуулсан нөхцөл ("Нөхцөл")-д, Банкны Дүрмийн 13.7 дахь хэсэгт өөрчлөлт оруулахаар ТУЗ 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн R-2023-79 тоот тогтоолоор шийдвэрлэснийг;
3. Дээр дурдсаны дагуу, гүйцэтгэх удирдлага нь Банкны дүрмийн монгол болон англи эх агуулгын хувьд ижил эсэхийг хараат бус хуулийн зөвлөхөөр нягтлуулсныг; мөн
4. Дээрх Нөхцөлийг хангах зорилгоор, Банкны Дүрэмд тогтоолын хавсралтад заасан нэмэлт, өөрчлөлт оруулахыг ТУЗ санал болгож буйг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын а) 1 дүгээр хавсралтаар Банкны Дүрмийн монгол эхэд оруулах нэмэлт, өөрчлөлт, б) 2 дугаар хавсралтаар монгол болон англи эхэд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталж, Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



САНЖАЙ ГҮПТА

Н.МӨНХЦЭЛМЭГ

ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолын Хавсралт 1



**ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ: МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ЭХИЙГ АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ
ЭХЭД НИЙЦҮҮЛЭХ
(Монгол хэл дээрх эхэд оруулах нэмэлт, өөрчлөлтүүд)**

	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт
1.	1.5.25 “Super Majority” shall mean no less than 66.67 (sixty six and sixty seven hundredths) percent of the total number of votes, voting rights, shares, or shareholders where applicable as the context may require;	1.5.25 “Дийлэнх олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67 (жаран зургаа зууны жаран долоо)-оос дээш хувийг;	1.5.25 “Дийлэнх олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67 (жаран зургаа зууны жаран долоо)-оос доошгүй дээш хувийг;
2.	1.5.26 “Ultra Majority” shall mean no less than 75 (seventy five) percent of the total number of votes, voting rights, shares, or shareholders where applicable as the context may require;	1.5.26 “Үнэмлэхүй олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75 (далан тав)-аас дээш хувийг;	1.5.26 “Үнэмлэхүй олонх” гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75 (далан тав)-аас доошгүй дээш хувийг;
3.	5.4.8.(2) making false statements to investigators in order to materially impede a Bank investigation into allegations of a Prohibited Practice;	5.4.8.2 Хориглосон үйл ажиллагааны хүрээнд Банкинд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах;	5.4.8.2 Хориглосон үйл ажиллагаа байж болзошгүй тохиолдлын ажиллагааны хүрээнд Банкинд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд ноцтой саад учруулах зорилгоор хянан шалгагч нарт худал жуурамч мэдээлэл өгөх;
4.	7.7 Subject to clause 7.6 above, the total quantity, par value, interest rate, periods for interest payments, price and redemption price of the additional Shares and other securities convertible to Shares, and convertibility of the securities into the Shares shall be determined by the BoD for the final approval and resolution from the shareholders’ meeting.	7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон бусад үнэт цаас, хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.	7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон Хувьцаанд хөрвөх бусад үнэт цаасны цаас; хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнэ болон үнэт цаасны Хувьцаанд хөрвөх нөхцөлийг үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
5.	8.5 Except as otherwise provided in the Applicable Law or this Charter, decisions of the shareholders’ meeting shall be made by a Simple Majority vote of shareholders present in person or by proxy at such meeting and eligible to vote on the matter. Each shareholder present in person or by proxy at the meeting shall have	8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон хувьцаа эзэмшигчдийн Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд	8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, өрөлцөөн тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн

	one vote for each Share of which he /she is the holder.	биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.	Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.
6.	8.6. (vii) making any investments including by way of deposits, loans, share capital in any concern other than in the ordinary course of business for the amount exceeding 2 (two) percent of the total equity of the Bank as per the most recent audited accounts of the Bank, in accordance with IFRS;	8.6. (vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр компанид хөрөнгө оруулах;	8.6. (vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, <u>хувь нийлүүлсэн</u> хөрөнгө <u>хуваах</u> зэргээр компанид хөрөнгө оруулах;
7.	8.6. (xi) the sale, conveyance, transfer, rent or other disposition of any assets with a value of more than 25 (twenty five) percent of the total assets of the Bank.	8.6. (xi) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны нийт хөрөнгийн 25 (хорин тав) хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, тээвэрлэх, шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.	8.6. (xi) <u>Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр</u> Банкны нийт хөрөнгийн 25 (хорин тав) хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, <u>өмчлөх эрхийг шилжүүлэх</u> <u>тээвэрлэх</u> , шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.
8.	8.26.2 making any investments including by way of deposits, loans, share capital in any concern other than in the ordinary course of business for the amount up to 2 (two) percent of the total equity of the Bank as per the most recent audited accounts of the Bank, in accordance with IFRS;	8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;	8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн 2 (хоёр) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, <u>хувь нийлүүлсэн</u> хөрөнгө <u>хуваах</u> зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;
9.	10.2 Any dissolution shall be implemented by a Dissolution Commission which shall be appointed by the BoD or the trustee appointed by the court, in the event the dissolution is by a court decision.	10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах тохиолдолд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс томилогдсон Татан буулгах комисс хэрэгжүүлнэ.	10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс <u>эсхүл шүүхийн шийдвэрээр</u> татан буулгах тохиолдолд <u>шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс</u> томилогдсон Татан буулгах комисс <u>эсхүл шүүхийн шийдвэрээр</u> татан буулгах тохиолдолд <u>шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгч</u> хэрэгжүүлнэ.
10.	11.2.2 Perform their duties in good faith, not provide unlawful or unethical advantage to themselves, their family, relatives, nor others who are in business or	11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, болон ажил төрлийн	11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба <u>банкны үйл ажиллагаа</u> , <u>тогтоосон горимд</u> <u>харш байдлаар</u> өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, болон ажил

	have personal relations with them or their family or relatives; Unless otherwise specified in law or internal rules and regulations, not disclose to others, or allow to be used by others, or use for private interest, any information about customers' accounts statements, loans, transactions and documents related to the business activities, figures, internal procedures, regulations, terms and conditions.	болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус давуу байдал олгохгүй байх; Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.	төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус, <u>ёс зүйд үл нийцэх байдлаар</u> давуу байдал олгохгүй байх; Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, <u>заавар нөхцөл, болзлуудыг нөхцөлүүдийг</u> хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад <u>задруулах танилцуулах</u>, ашиглуулах, <u>нууцлалыг алдагдуулах</u>, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.
11.	12.1.1 insure and keep insured on terms and conditions acceptable to the shareholders, with a reputable insurer or insurers all its assets, business and liabilities which can be insured, against insurable losses, on a reinstatement basis utilizing current full replacement values, and any other insurance required by law. The policies shall be in the English language;	12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага мөн хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад эрсдэлийг салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр даатгуулах буюу өмнө байгуулсан гэрээний хугацааг сунгана. Даатгалын гэрээг англи хэл дээр байгуулна;	12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага, <u>аливаа бусад даатгалын зүйл болохуйц эрсдэлийг одоогийн үнээр нь нөхөн төлөх нөхцөлөөр мөн хуульд-заавал-даатгуулахаар заасан аливаа бусад-эрсдэлийг</u> салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр <u>даатгуулж, уг даатгалуудыг хүчин төгөлдөр хэвээр байлгах ба үүнд хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад даатгал мөн орно. даатгуулах-буюу-өмнө байгуулсан-гэрээний-хугацааг сунгана.</u> Даатгалын гэрээг англи хэл дээр байгуулна;
12.	13.3 This Charter shall be amended only by an Ultra Majority vote of shareholders present at the meeting in person or by proxy and eligible to vote on such matter. Each shareholder present in person or by proxy shall have one vote for each Share of which he /she is the holder.	13.3 Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.	13.3 Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, <u>тухайн асуудлаар санал өгөх эрхтэй</u> гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрд нэг саналын эрх эдэлнэ.



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолын Хавсралт 2

**ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ: ЗӨРҮҮТЭЙ БАЙДАЛ ҮҮССЭН ТОХИОЛДОЛД МОНГОЛ
ХЭЛ ДЭЭРХ ЭХИЙГ БАРИМТЛАХААР ТОГТООХ**
(Монгол болон Англи хэл дээрх эх тус бүрт оруулах өөрчлөлт)

Одоогийн англи заалт	Өөрчлөлт орсон англи заалт
13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English version shall prevail in any discrepancies in the two versions.	13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English Mongolian version shall prevail in any discrepancies in the two versions.

Одоогийн монгол заалт	Өөрчлөлт орсон монгол заалт
13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон Монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална.	13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл АНГЛИ МОНГОЛ хэл дээрх эхийг баримтална.



Хувьцаа эзэмшигчдийн хурлын ТОГТООЛЫН ТӨСӨЛ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

[төсөл]

ХасБанк ХК-ийн Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХасБанк ХК (“Банк”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд зохион байгуулсан эчнээ санал хураалтын үр дүнд дараах шийдвэрийг гаргав:

ТЭМДЭГЛЭХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”) 2023 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 9/3889 тоот албан бичгээр Банкны Дүрмийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг дахин хянаж үзэхийг зөвлөмж болгосныг;
2. Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) нь СЗХ-ны зөвлөмжийн дагуу, 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн R-2025-27 дугаар тогтоолоор (а) Банкны Дүрмийн англи эхэд нийцүүлж монгол эхэд нэмэлт, өөрчлөлт оруулах (“**Нийцүүлэх нэмэлт, өөрчлөлт**”), мөн (b) монгол болон англи эхийн хооронд зөрүүтэй байдал үүссэн тохиолдолд монгол хэл дээрх эхийг баримтлахаар тогтоож, монгол болон англи эх тус бүрд өөрчлөлт оруулах (“**Баримтлах хэлний өөрчлөлт**”)-аар санал болгосныг; мөн
3. Хувьцаа эзэмшигчид нь дараах шийдвэр гаргахыг дэмжсэн болохыг тус тус тэмдэглэв.

ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын 1.1 дэх хавсралтад тусгасан Нийцүүлэх нэмэлт, өөрчлөлтийг [баталсугай/баталж] [мөн энэхүү тогтоолын 1.2 дахь хавсралтад тусгасан Нийцүүлэх нэмэлт, өөрчлөлтийг батлахаас татгалзсугай].
2. Энэхүү тогтоолын 2 дугаар хавсралтад тусгасан Баримтлах хэлний өөрчлөлтийг [баталсугай/батлахаас татгалзсугай].
3. Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Мөнхцэлмэгт энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу Монголбанк, СЗХ болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт Банкны нэрийн өмнөөс холбогдох аливаа баримт бичгийн хамт хүргүүлж бүртгүүлэхийг даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА

САНЖАЙ ГҮПТА

ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ: МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ЭХИЙГ АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ЭХЭД НИЙЦҮҮЛЭХ

Хавсралт 1.1

(Монгол хэл дээрх эхэд оруулахаар батлагдсан нэмэлт, өөрчлөлтүүд)

	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт
1	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]
2	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]
3	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдсан нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]

ДҮРМИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ: МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ЭХИЙГ АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ЭХЭД НИЙЦҮҮЛЭХ

Хавсралт 1.2

(Монгол хэл дээрх эхэд оруулахаар батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтүүд)

	Англи заалт	Одоогийн монгол заалт	Нэмэлт, өөрчлөлт орсон монгол заалт
1	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]
2	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]
3	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн англи хувилбарыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийн монгол хэл дээрх одоогийн заалтыг энд оруулна]	[Батлагдаагүй нэмэлт, өөрчлөлтийг энд оруулна]

**ДҮРЭМД ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ: ЗӨРҮҮТЭЙ БАЙДАЛ
ҮҮССЭН ТОХИОЛДОЛД МОНГОЛ ХЭЛ ДЭЭРХ ЭХИЙГ
БАРИМТЛАХААР ТОГТООХ**

Хавсралт 2

(Монгол болон англи хэл дээрх эх тус бүрд оруулахаар [батлагдсан/батлагдаагүй] өөрчлөлт)

Одоогийн англи заалт	Өөрчлөлт орсон/Батлахаас татгалзсан англи заалт
13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English version shall prevail in any discrepancies in the two versions.	13.7. This Charter is made in both English and Mongolian languages with same effect and force. The English <u>Mongolian</u> version shall prevail in any discrepancies in the two versions.

Одоогийн англи заалт	Өөрчлөлт орсон/Батлахаас татгалзсан монгол заалт
13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи хэл дээрх эхийг баримтална.	13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд англи болон монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл англи <u>монгол</u> хэл дээрх эхийг баримтална.

ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
06 сарын 27-ны өдрийн R-2025-28 дугаар тогтоолын Хавсралт 3

Комиссын дарга: Б.Ананд, Партнер, Кэй И Партнерс ХХН

Комиссын гишүүд: Т.Отгон, Хуульч, Кэй И Партнерс ХХН

Г.Хажидмаа, Эрх зүйч, Кэй И Партнерс ХХН



Саналын хуудасны загвар

САНАЛЫН ХУУДАСНЫ ЗАГВАР

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
06 сарын 27-ны өдрийн R-2025-28 дугаар тогтоолын Хавсралт 4

Компанийн нэр: ХасБанк ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн хооронд ХасМийтинг аппликейшнээр дамжуулан эчнээ санал хураалтын хэлбэрээр, цахимаар саналаа өгнө.

Д/д	Шийдвэрлэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1.	Монгол хэл дээрх Дүрмийн 1.5.25 дугаар заалтад өөрчлөлт оруулах	☐	☐	☐
2.	Монгол хэл дээрх Дүрмийн 1.5.26 дугаар заалтад өөрчлөлт оруулах	☐	☐	☐
3.	Монгол хэл дээрх Дүрмийн 5.4.8.2 дугаар заалтыг өөрчлөн найруулах	☐	☐	☐
4.	Монгол хэл дээрх Дүрмийн 7.7 дугаар хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
5.	Монгол хэл дээрх Дүрмийн 8.5 дугаар хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
6.	Монгол хэл дээрх Дүрмийн 8.6. (vii) дугаар хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах	☐	☐	☐
7.	Монгол хэл дээрх Дүрмийн 8.6. (xi) дугаар хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
8.	Монгол хэл дээрх Дүрмийн 8.26.2 дугаар заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах	☐	☐	☐
9.	Монгол хэл дээрх Дүрмийн 10.2 дахь хэсгийг өөрчлөн найруулах	☐	☐	☐
10.	Монгол хэл дээрх Дүрмийн 11.2.2 дугаар заалтыг өөрчлөн найруулах	☐	☐	☐
11.	Монгол хэл дээрх Дүрмийн 12.1.1 дүгээр заалтыг өөрчлөн найруулах	☐	☐	☐

12.	Монгол хэл дээрх Дүрмийн 13.3 дугаар хэсэгт нэмэлт оруулах	☐	☐	☐
13.	Монгол болон англи хэл дээрх Дүрмийн 13.7 дугаар хэсэгт өөрчлөлт оруулах	☐	☐	☐

Тайлбар/Санамж:

1. Та эчнээ саналаа заасан хугацаанд зөвхөн ХасМийтинг аппликейшнээр дамжуулан цахим хэлбэрээр өгөх боломжтой.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн саналаа өгөх бол төлөөлөх хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн итгэмжлэлийг ирүүлэн саналаа өгсөн тохиолдолд таны санал хүчинтэйд тооцогдоно.

Энэ хэсгийг ХЭЭБХ-ын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм / Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, тайлал: _____ / _____

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон үндэслэл: _____
